



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 12

Мандалговь

**Т.Өлзий-Оршихыг Гурвансайхан сумын
цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай**


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын Төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Гурвансайхан сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Төмөр-Очирын Өлзий-Орших 58.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Т.Өлзий-Оршихын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Гурвансайхан сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд
нэр дэвшүүлсэн Т.Өлзий-Оршихын тухай дүгнэлт**

1. Т.Өлзий-Орших нь 1983 онд Дундговь аймгийн Гурвансайхан суманд төрсөн. 39 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2001-2005 онд Соёлын дээд сургуулийг хөгжмийн багш мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2005-2007 онд Сайнцагаан сумын 5 дугаар цэцэрлэгт хөгжмийн багш, 2007 оноос Гурвансайхан сумын цэцэрлэгт багшаар ажиллаж байна.
4. Т.Өлзий-Орших нь тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Гурвансайхан сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ